



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/12

Зуунмод

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн
үед авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “ж”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 10.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл бүхий худалдааны цэгүүдэд 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн архи, согтууруулах ундаа худалдан борлуулахыг зөвшөөрч, аймгийн Засаг даргын 2018 оны А/340 тоот захирамжийн дагуу сар бүрийн 01-ний өдөр болон долоо хоног бүрийн лхагва гарагт худалдан борлуулахыг хориглосугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/03 тоот захирамжийн 1.3 дахь заалтын “18 хувь хүртэлх спиртын агууламжтай” гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах явцад хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /У.Өлзийцэцэг/, Цагдаагийн газар /Б.Ганзориг/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Сурмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР